# 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



# ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .......... 3

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .......... 5

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .......... 5

2.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө .......... 11

2.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .......... 13

2.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .......... 19

Хүснэгт 6. Усны шинжилгээний үр дүн .......... 24

2.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .......... 26

2.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах .......... 29

## Зургийн жагсаалт

*Зураг 1. Судалгааны талбайн харагдах байдал* ........ 4
*Зураг 2. Судалгааны талбайн байршил* ........ 4
*Зураг 3. Химийн бодисын агуулахад байрлах химийн бодис хадгалах ган шүүгээ болон асгарсан бодис шингээгч материал* ........ 8
*Зураг 4. Задгай агуулахад байрлах химийн бодис асгарсан бодис шингээгч материал байнгын бэлэн байдаг* ........ 9
*Зураг 5. Лабораторид байрлах самбарууд* ........ 10
*Зураг 6. Хог хаягдал ангилан хаях хогийн сав* ........ 15
*Зураг 7. Гялгар уут болон цаасны хаягдал түр хадгалах цэг* ........ 16
*Зураг 8. Мод болон төмрийн хаягдал түр хадгалах цэг* ........ 16
*Зураг 9. Аюултай хог хаягдал болох тостой хаягдал, химийн бодисын сав, баглаа түр хадгалах цэг* ........ 16
*Зураг 10. Судалгааны талбайн агаарын чанарын хэмжилтийн дүн, мг/м$^3$* ........ 20
*Зураг 11. Гүний худгуудын байршил* ........ 24
*Зураг 12. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлууд* ........ 27
*Зураг 13. 🌸ЭРХЭМ НАНДИН ТӨСӨЛ🌸* ........ 28
*Зураг 14. Хорооны оршин суугчдын хүлээн авч уулзаж буй байдал* ........ 29
Зураг 15. 25-р хорооны иргэдийн нийтийн хурал, 2025.09.24 ........ 30

## Хүснэгтийн жагсаалт

*Хүснэгт 1. Судалгааны талбайн агаарын чанарын шинжилгээ* ........ 19
*Хүснэгт 2. Хөрсний дээж авсан цэг, 2025.03.14* ........ 20
*Хүснэгт 3. Хөрсний үржил шимт чанар* ........ 22
*Хүснэгт 4. Хөрсний механик шинж чанар* ........ 23
*Хүснэгт 5. Хөрсний хүнд элементийн агууламж* ........ 23
Хүснэгт 6. Усны шинжилгээний үр дүн ........ 24

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Барловорлд Монголиа” ХХК нь 1996 оноос Монгол улсад уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэгийг ханган нийлүүлэх, засварлах, түрээслэх үйл ажиллагаагаа сүүлийн 25 жилийн турш тасралтгүй явуулж байна. Үйл ажиллагаа нь Өмнөговь аймгийн Ханбогд сум, Цогтцэций сум, Гурвантэс сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сум зэрэг олон салбартай боловч Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт гол үндсэн үйл ажиллагаа явагддаг.

“Барловорлд Монголиа” ХХК нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн хуучнаар 4-р хороо, одоогийн 25-р хорооны нутаг дэвсгэрт нэг доор зэрэгцээ орших доорх 3 хэсэг газарт үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. Нийслэлийн засаг даргын 2017 оны А/488 тоот захирамжаар олгосон 000001866 тоот газар ашиглах гэрчилгээтэй 7994 $м^2$ талбайтай газар
2. Нийслэлийн засаг даргын 2022 оны А/0623 тоот захирамжаар олгосон 0000082889 тоот газар ашиглах гэрчилгээтэй 14741 $м^2$ талбайтай газар
3. Өөрийн охин компани болох “Глобал шарын гол” ХХК-ийн эзэмшилд байдаг Нийслэлийн засаг даргын 2021 оны А/104 тоот захирамжаар олгосон 000028842 тоот газар эзэмших гэрчилгээтэй 9268 $м^2$ талбайтай газруудад үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 3 хэсэг газрын талбайн нийлбэр 32003 $м^2$.

Тус төсөл нь хүнд машин механизмын засвар үйлчилгээ хийж, хүнд машин механизмын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдаалдаг. Өөрийн гэсэн засвар үйлчилгээний төвтэй. Энэ төвийн зорилго нь уул уурхай болон бусад хүнд үйлдвэрүүдэд шаардлагатай хүнд даацын машин, механизмыг худалдах, сэлбэг хэрэгслийг нийлүүлэх, тэдгээрийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх юм. Зарим засвар үйлчилгээг хийхэд тухайлбал хөдөлгүүрийн гэмтэл, доголдлыг илрүүлэхэд лабораторид химийн бодис ашиглах шаардлага урган гардаг. Иймээс төсөл хэрэгжүүлэгч нь Катерпилларын S·O·S шингэний шинжилгээний лаборатори байгуулжээ. Катерпилларын S·O·S шингэний шинжилгээний лаборатори нь тосны болон хөргөлтийн шингэний дээжид ашиглалтын шинж чанарын шинжилгээг олон улсын стандартын шаардлагад нийцсэн технологиор хийдэг.

2025 онд нийт 500 орчим ажилтантай үйл ажиллагаа явууллаа.

“Хүнд машин механизмын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн худалдаа, сэлбэгийн агуулах” төсөл нь 3 үндсэн хэсэгтэй.

***Төв оффис.*** Энд тус компанийн захирал, удирдах албан хаагчид суух бөгөөд мөн машин механизмын бүхий л засвар үйлчилгээ хийгддэг. Машины мотор болон бусад эд ангиудыг засах засварын цех, машин угаалга зэрэг үйлчилгээ энэ хэсэгт байрладаг.

***Түрээс.*** Машин механизмын зарим жижиг засвар хийгддэг. Мөн цахилгаан үүсгүүр, жижиг машин механизмыг энэ хэсэгт түрээсэлж худалдаалдаг.

***Баруун оффис.*** Тус байранд өөрсдийн худалдан борлуулж буй сэлбэг хэрэгслийг хадгалдаг агуулахтай, мөн оффисын ажилчид суудаг.




*Зураг 1. Судалгааны талбайн харагдах байдал*



*Зураг 2. Судалгааны талбайн байршил*

# 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | Химийн бодис асгарсан тохиолдолд ажилтнуудын арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий стандартын шаардлага хангасан хамгаалалтын хэрэгсэлтэй, асгарсан бодисыг шингээгч оймс (socks), алчуур (pad), дэр (pillow) зэргийг багтаасан АНУ-д үйлдвэрлэгдсэн BOWHEAD Environmental and Safety компанийн тусгай зориулалтын асгаралтын эсрэг иж бүрдэл SPILL RESPONSE KIT-ийг байнгын бэлэн байдалд байлгах | Химийн бодисын агуулах болон шатах тослох материал хадгалж буй агуулах, гадаах талбайд АНУ-д үйлдвэрлэгдсэн BOWHEAD Environmental and Safety компанийн тусгай зориулалтын асгаралтын эсрэг иж бүрдэл SPILL RESPONSE KIT-ийг байнгын бэлэн байдалд байлгадаг.     |    |
| 2. | Органик болон органик биш шингэн бодисуудын савны битүүмжлэлийг байнга шалгах | Лабораторийн ажилчид химийн бодисын агуулахад хадгалагдаж байгаа болон лабораторид хэрэглэж байгаа бодисуудын таглаа, бүрэн бүтэн байдлыг байнга шалгадаг. |  |
| 3. | Хүчтэй хүчиллэг эсвэл шүлтлэг орчин үзүүлдэг шингэн бодисуудыг агуулахын гадна болон дотор асгарсан тохиолдолд нэн даруй шингээгч материалаар шингээн авч аюултай хог хаягдал түр хадгалах саванд хадгалан мэргэжлийн байгууллагаар устгуулах | Бид асгаралтын журам HSE-SOP-05-02-01-д заасны дагуу асгаралтын хэмжээнээс үл хамааран мэдээлж, яаралтай цэвэрлэх үүрэг хүлээн ажилладаг. Мөн тухайн бодисын ХАЛМ /MSDS/-д заасны дагуу ажилтан өөрийгөө хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэт өмсөж тухайн бодистой харьцаж ажиллана. |  |

| | | | |
|---|---|---|---|
| 4. | Асгарсан хуурай бодисыг тоос үүсгэхээргүй байдлаар цэвэрлэж аюултай хог хаягдал түр хадгалах саванд хадгалан мэргэжлийн байгууллагаар устгуулах | | |
| 5. | Агааржуулалтын системийн найдвартай ажиллагаа хангах, тогтмол шалгах, шаардлагатай үед засвар үйлчилгээ хийх | Агуулах нь бүрэн агааржуулах системтэй. Агуулахын температур нь бодисын хадгалах нөхцөлд тохирсон тогтмол температуртай байвал зохих учраас эйр кондийшн буюу халуун хүйтэн агаар үлээгчийг суурилуулсан. Химийн бодисыг зөв хадгалах горимын дагуу тус өрөөний температурыг өдөрт 2 удаа хянаж, тэмдэглэл хөтөлдөг. |  |
| 6. | Галын самбар, гал унтраах хэрэгслүүдийг зохих газруудад байрлуулж галын хоруудыг хугацаанд нь цэнэглүүлж байх | Агуулах, лаборатори, засварын газар, оффис зэрэг шаардлагатай газруудад гал унтраах хэрэгслүүдийг байрлуулж галын хорыг цэнэглэж тогтмол цэнэглэж байна.      |  |
| 7. | Химийн бодисуудыг зөв хаягжуулж, хор аюулын лавлахад заасан зөвлөмжийн дагуу хадгалах | Төслийн БОННҮ-ий тайланг 2019, 2022, 2023 онуудад хийлгэж байсан. Тус тайлангийн “Эрсдэлийн үнэлгээ” бүлэгт заасан бодис тус бүрийг яаж хадгалах талаарх зөвлөмж болон химийн бодисуудыг хор аюулын лавлахад заасны дагуу MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан агуулахад хадгалдаг. |  |
| 8. | Химийн бодисуудыг зөв хаягжуулж, хор аюулын лавлахад заасан зөвлөмжийн дагуу хадгалах | | |
| 9. | Химийн бодисын асгарсан тохиолдолд шингээгч материалаар шингээж бохирдсон материалыг мэргэжлийн байгууллагаар устгуулах | 2025 онд химийн бодисын асгаралт явагдаагүй.<br>Хэрэв асгаралт явагдаж шингээсэн тохиолдолд химийн бодис арчсан шингээх материалуудыг мэргэжлийн байгууллага болох “Түмэн эгшиг” ХХК-д нийлүүлнэ. | Гэрээг хавсаргав. |

| | | | |
|---|---|---|---|
| 10. | Аюулгүйн ажиллагааны зааварчилгаар боловсруулж агуулахад ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах | MNS 4969:2000 стандартад нийцүүлэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын байрны өдөр тутмын зааварчилгаа өгдөг. Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг улирлын онцлогоос хамааран жилд 2 удаа нийт 4 ээлжийн хувцсыг компанийн HSE-SOP-01-04-01 /Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, тэдгээрийг ашиглах/ журам-д нийцүүлэн тараадаг. |    |
| 11. | Химийн хорт болон аюултай бодисуудын H-аюулын тэмдэглэгээ, P-анхааруулах тэмдэглэгээ, сэрэмжлүүлэх үг, дүрс тэмдэглэгээнүүдийг багтаасан хаягжуулалтыг агуулахад хадгалагдаж буй бодис нэг бүр дээр бүрдүүлэх | Химийн бодисын агуулахад хадгалж буй бодис бүрийн анхааруулах, хор аюулын тэмдэглэгээнүүдийг багтаасан хаягжуулалтыг химийн бодисын агуулахад байрлуулсан. |  |

## 1. Асгаралтын иж бүрдэл

Химийн бодисын агуулах, засварын газар, задгай агуулах зэрэг шаардлагатай газруудад болзошгүй ослын үед буюу химийн бодис асгарсан тохиолдолд ажилтнуудын арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий, стандартын шаардлага хангасан хамгаалалтын хэрэгсэлтэй, асгарсан бодисыг шингээгч оймс (socks), алчуур (pad), дэр (pillow), усны гутал, хувцас зэргийг багтаасан АНУ-д үйлдвэрлэгдсэн BOWHEAD Environmental and Safety компанийн тусгай зориулалтын асгаралтын эсрэг иж бүрдэл SPILL RESPONSE KIT-ийг байнгын бэлэн байдалд байлгаж байна.




*Зураг 3. Химийн бодисын агуулахад байрлах химийн бодис хадгалах ган шүүгээ болон асгарсан бодис шингээгч материал*





*Зураг 4. Задгай агуулахад байрлах химийн бодис асгарсан бодис шингээгч материал байнгын бэлэн байдаг*

## 3. Асгаралттай ажиллах

Бид асгаралтын журам HSE-SOP-05-02-01-д заасны дагуу асгаралтын хэмжээнээс үл хамааран мэдээлж, яаралтай цэвэрлэх үүрэг хүлээн ажилладаг. Мөн тухайн бодисын ХАЛМ /SDS/-д заасны дагуу ажилтан өөрийгөө хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэт өмсөж тухайн бодистой харьцаж ажиллана.



**а.** Шингээгч хязгаарлагч 2 ш олгойг тойруулан тавьж, шингээгч алчуураар арчина.

**б.** Зориулалтын уутанд ашигласан шингээгч болон цэвэрлэсэн материалыг хийж амыг нь зангидаж зориулалтын саванд түр хадгалан мэргэжлийн байгууллагаар устгуулна.

## 11. Химийн бодисын хаягжуулалт

Химийн хорт болон аюултай бодисуудын H-аюулын тэмдэглэгээ, P-анхааруулах тэмдэглэгээ, сэрэмжлүүлэх үг, дүрс тэмдэглэгээнүүдийг багтаасан хаягжуулалтыг агуулахад хадгалж буй бодисууд дээр бүрдүүлсэн.




*Зураг 5. Лабораторид байрлах самбарууд*

## 2.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Орчны тохижилт болон Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих | Тэрбум мод болон орчны тохижилтын хүрээнд 200ш мод тарьж ургуулах. Өөрийн эзэмшил газарт тарих талбай байхгүй учир өөр газар тарьж ургуулна. | **ХАВАР-ын мод тарилт.** Олон улсын цэцэрлэгт хүрээлэнд 200ш тэхийн шээг мод тарьсан. **НАМАР-ын мод тарилт.** Баянгол дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 120 ширхэг Хайлаас болон гацуур мод тарьсан. Жил бүр мандлын цэцэг тарьж компанийн гадна талбайн тохижилт болон ажилтнууд болон харилцагч нартээрэг сэтгэгдэл төрүүлэх зорилготой 500-700 ширхэг нэг наст цэцэг тарьдаг. |

### МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР - 2025

Бид жил бүр үндэсний мод тарих өдрийг тохиолдуулан жил 2 удаа (намар, болон хаврын) мод тарьдаг уламжлалынхаа дагуу модоо тарсан.

**ХАВАР-ын мод тарилт.** Олон улсын цэцэрлэгт хүрээлэнд 200ш тэхийн шээг мод тарьсан













**НАМАР-ын мод тарилт.** Баянгол дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 200ш Хайлаас болон 20 ширхэг Гацуур мод тарьсан.











## ОРЧНЫ ТОХИЖИЛТ

Жил бүр мандлын цэцэг тарьж компанийн гадна талбайн тохижилт болон ажилтнууд болон харилцагч нарт сайхан сэтгэгдэл төрүүлэх зорилготой.







## 2.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Бүх хог | Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах<br>- Төмрийн хаягдал<br>- Цаасны хог хаягдал<br>- Хуванцар хаягдал<br>- Тостой хаягдал<br>- Хоол хүнсний хаягдал<br>- Батарей<br>- Мод<br>- Шатах тослох материалын хаягдал<br>- Бусад хаягдал | Оффисын ажилтан бүрийн ширээний доор байсан 200 орчим хогийн савыг аваад, коридорт нэгдсэн байдлаар компанийн Хог хаягдлын журмын дагуу эх үүсвэр дээр нь хогоо ангилах зорилготой ангиллын хогийн сав байршуулсан. |  |
| | | | Засварын цех дээр гарч байгаа хог хаягдлын төрлөөс шалтгаалаад эх үүсвэр дээр нь 5 төрлөөр ангилах хогийн савыг байршуулсан. |  |
| | | | Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв хаягдал батарейг авахгүй болсон тул бид дотооддоо хадгалж байна. |  |
| 2 | Энгийн хог хаягдал | Шил лааз, хуванцар сав, цаас, гялгар уут, төмөр, мод гэх мэт дахин ашиглах боломжтой хог хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах | Гялгар уут, цаасны хаягдал гэх мэт дахин боловсруулагддаг хог хаягдлыг хоёрдогч түүхий эд боловсруулдаг “Түвшин сайхан” ХХК-д нийлүүлж байна. | Гэрээг хавсаргав. |
| 3 | | Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин ашиглаж үлдсэн энгийн хог хаягдлыг дүүргийн ТҮК-д нийлүүлэх | Үлдэгдэл энгийн хог хаягдлыг Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-т гэрээгээр хүлээлгэн өгч байна. | Гэрээг хавсаргав. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | Аюултай хог хаягдал | Химийн бодис, шатах тослох материалын сав, баглаа боодол, үлдэгдэл, химийн бодис арчсан даавуу, хувцас зэрэг аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллага болох "Цэцүүх трейд" ХХК-тай гэрээлэн устгуулах | Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа, тостой даавуу, тостой хувцас зэрэг аюултай хог хаягдлыг "Түмэн эгшиг" ХХК-тай гэрээлэн устгуулж байна. | Гэрээ хавсаргав. |
| 7 | | Хаягдал тос, тосолгооны материалыг мэргэжлийн байгууллага болох "Хай би ойл" ХХК-аар гэрээлэн устгуулах | "Хай би ойл" ХХК-аар гэрээлэн устгуулж байгаа. | Гэрээ хавсаргав. |

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаанаас ялгарч буй бүхий л хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг. Ажлын байр, засварын газрууд, агуулах гэх мэт шаардлагатай газруудад цаасны хаягдал, тостой хаягдал, хуванцар хаягдал, ердийн хаягдал гэх мэт ангилал бүхий хогийн савнуудыг байрлуулан ангилан түр хадгалж байна. Өмнө нь ангилан ялгалгүй бүх хогоо хийдэг байсан оффисын ажилтан бүрийн ширээн доорх хогийн савнуудыг авч батерей, принтерын хор, цаас, хуванцар, энгийн зэрэг ангилал бүхий хогийн савнуудыг коридорт байрлуулан хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан хаяж байна.



*Зураг 6. Хог хаягдал ангилан хаях хогийн сав*

Төслийн хашаанд хог хаягдлаа ангилан ялгаж түр хадгалан мэргэжлийн байгууллагуудад нийлүүлдэг. Тухайлбал: гялгар уут, цаасны хаягдал гэх мэт дахин боловсруулагддаг хог хаягдлыг хоёрдогч түүхий эд боловсруулдаг “Түвшин сайхан” ХХК-д, химийн бодисын үлдэгдэл, сав баглаа, тостой хаягдлыг “Түмэн эгшиг” ХХК-д, мод, төмөр болон шил, лааз, хуванцар савны хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт, хаягдал тосыг “Хай би ойл” ХХК-д нийлүүлж үлдсэн энгийн хатуу хог хаягдлыг “Баянгол шинэ өргөө” ОНӨААТҮГ, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-аар зайлуулж байна. Хог хаягдлын гэрээнүүдийн хуулбарыг хавсаргав.



*Зураг 7. Гялгар уут болон цаасны хаягдал түр хадгалах цэг*



*Зураг 8. Мод болон төмрийн хаягдал түр хадгалах цэг*







*Зураг 9. Аюултай хог хаягдал болох тостой хаягдал, химийн бодисын сав, баглаа түр хадгалах цэг*




БИДНИЙ АНГИЛСАН ХОГ ХАЯГДЛЫН ЭЦСИЙН ПРОЦЕСС – ГЯЛГАР УУТ, ХУВАНЦАР




БИДНИЙ АНГИЛСАН ХОГ ХАЯГДЛЫН ЭЦСИЙН ПРОЦЕСС - ЦААС




БИДНИЙ АНГИЛСАН ХОГ ХАЯГДЛЫН ЭЦСИЙН ПРОЦЕСС – АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

Аюултай хог хаягдлыг тусгай цэгт хадгалан мэргэжлийн байгууллагад хариуцлагатайгаар устгуулдаг.








## 2.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Давтамжийн тоо | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| **Агаарын чанар** | | | | | |
| 1 | - PM10<br>- SOx<br>- NOx<br>- Дуу шуугиан | - Талбайн гадна | Жилд 1 удаа | Төслийн талбай болох БГД-ийн 25-р хороонд орших өөрийн байрны гадна талбайд 2025.02.21-д сорьц авч шинжилгээ хийлгэв. | Шинжилгээний хариуг хавсаргав. |
| **Хөрс** | | | | | |
| 2 | - Агрохими<br>- Хүнд металл | - Ногоон байгууламж бүхий талбай | Жилд 1 удаа | 2025 оны 3 сарын 14-д “Түрээс”-ийн урд хэсэгт хөрсний зүсэлт хийж, дээж авч шинжлүүлэв. | Шинжилгээний хариуг хавсаргав. |
| **Ус** | | | | | |
| 3 | - Анион, катион<br>- Хүнд металл | - Гүний 3 худаг | Жилд 1 удаа | Худаг тус бүрээс дээж авч Газарзүй-геоэкологийн хүрээлэнд шинжлүүлэв. | Шинжилгээний хариуг хавсаргав. |
| 4 | - Анион, катион<br>- Хүнд металл | - Баруун оффисоос гарах бохир ус<br>- Төв оффисоос гарах бохир ус<br>- Washbay-оос гарах бохир ус | Жилд 1 удаа | Усны газрын Усны лабораторид шинжлүүлэв. | |

### *1. Агаарын чанар*

Судалгааны талбайд 2025 оны 02-р сарын 21-ны өдөр Байгаль орчин хэмжилзүйн төв лабораториор агаарын чанарын хэмжилт хийлгэлээ. Хэмжилтээр хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээ гэсэн үзүүлэлтүүд MNS 4585:2016 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдолгүй байна.

*Хүснэгт 1. Судалгааны талбайн агаарын чанарын шинжилгээ*

| № | Сорьц авсан цэг | Хүхэрлэг хий, SO, мг/м³ | Азотын давхар исэл, NO, мг/м³ | Нийт тоос /TPS/, мг/м³ | Дуу чимээ, ДБА |
|---|---|---|---|---|---|
| 1 | Талбай орчим | 0.008 | 0.053 | 0.206 | 52 |
| 2 | Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 | 0.45 | 0.2 | 0.5 | 60 |




*Зураг 10. Судалгааны талбайн агаарын чанарын хэмжилтийн дүн, мг/м$^3$*

## *2. Хөрсний чанар*

Судалгааны талбай орчимд аллювийн болон хар хүрэн хөрсний төрлүүд тархах боловч судалгааны талбайн дийлэнх хэсэг барилга байгууламжид дарагдаж, хатуу хучилттай болсон.

Баруун оффисын зүүн урд, хойд хэсэг болон түрээсийн урд хэсэгт багахан хэмжээний талбай техноген нөлөөлөлд өртөөгүй хөрсөөр байна. 2018 оны хээрийн судалгаагаар “Түрээс”-ийн урд хэсгийн талбай шороо овоолсон, ургамалгүй чулуурхаг гадарга байсан бол 2021 онд гацуур, нохойн хошуу, улиас гэх мэт мод, бут сөөг тариалж, зүлэгжүүлсэн байна. 2025 оны 3 сарын 14-д тус талбайд хөрсний зүсэлт хийлээ.

*Хүснэгт 2. Хөрсний дээж авсан цэг, 2025.03.14*

| Зүсэлтийн дугаар | Байрлал | Координат | Хөрсний зүсэлтийн гүн, см |
|---|---|---|---|
| Зүсэлт-1 | Ердийн хар хүрэн | 47.905475° N, 106.86422° E | 20 |

### Зүсэлт – 1.

| | | | |
|---|---|---|---|
| **Аймгийн нэр:** | УБ хот | **Гадаргын налуу (градус):** | 0 |
| **Сумын нэр:** | БГД | **Ургамлын бүлгэмдэл, бүрхэц (%):** | 20 |
| **Газрын нэр:** | | **Чулуужилт (%):** | 5 |
| **Зүсэлтийн дугаар:** | Зүсэлт-1 | **Хөрсний давсжилт, намагжилт:** | Байхгүй |
| **Газар зүйн солбицол:** | 47.905475°<br>106.86422° | **Хөрсний эвдрэл:** | Хатуу хучилттай |
| **Өндөржилт (м):** | 1280-1281 | **Хөрсний бохирдолт:** | Байхгүй |
| **Хөрс газарзүйн муж:** | Ойт хээр | **Гадаргын элсэн бүрхэц (%):** | 5 |
| **Газрын гадарга:** | Тэгш | **Талбайн ашиглалт:** | Засварын газар |
| **Гадаргын фото:** | | | |





**Хөрсний үе давхаргын фото ба морфологи бичиглэл**



| | |
|---|---|
| A 0-20 см | Хар хүрэн өнгөтэй, хуурай, жижиг хэмдэст чулуутай, сийрэг, ургамлын үндэстэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, үе давхаргын шилжилт ургамлын үндэс, өнгө, чулуугаар тод ялгарна. |
| B 20↓ см | Хар хүрэн өнгөтэй, хуурай, жижиг хэмдэст чулуутай, сийрэг, ургамлын үндэстэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, үе давхаргын шилжилт ургамлын үндэс, |

| | |
|---|---|
| **Хөрсний нэр, код:** | Ердийн хар хүрэн хөрс |
| **Хөрсний дээж авсан гүн, см:** | 0-20 |

***Хөрсний химийн үндсэн шинж чанар***:

*Хөрсний урвалын орчин (pH).* Энэ үзүүлэлт нь хөрсний хүчиллэг болон шүлтлэгийг тодорхойлох үзүүлэлт болдог. Хөрсний pH-ээс тухайн хөрсөнд явагдах химийн үйл явцууд шууд болон урвуу хамааралтай байдаг. Хөрсний урвалын орчин 5.6-6.0 бол дунд зэрэг хүчиллэг, 6.1-6.5 сул хүчиллэг, 6.6-7.3 саармаг, 7.4-7.8 сул шүлтлэг, 7.9-8.4 дунд зэрэг шүлтлэг, 8.5-9.0 хүчтэй шүлтлэг гэж үздэг. Ерөнхийдөө хөрсний урвалын орчин сул хүчиллэгээс сул шүлтлэг буюу 5.6-8.4 байхад ургамал ургахад тохиромжтой гэж үздэг.

*Хөрсний карбонат.* Хөрсний карбонат гэдэг нь нүүрстөрөгчийн гуравч исэлтэй ($CO_3$)-тэй нэгдсэн газрын металлуудын (Ca, Mg) давс юм. Карбонатын тархалт, хэмжээ нь хөрсний үржил шим, элэгдэлд тэсвэртэй байдал, боломжит чийгийн багтаамжид нөлөөлдөг. Хөрсийг карбонатын агууламжаар нь 0% карбонатжаагүй, 0-2% сул карбонатжсан, 2-10% дунд зэрэг карбонатжсан, 10-25% хүчтэй карбонатжсан, >25% маш хүчтэй карбонатжсан гэж үнэлдэг. Хөрсний карбонатын агууламж дунд зэрэг буюу <10% байхад тохиромжтой гэж үзнэ.

*Хөрсний ялзмаг буюу органик карбон (C).* Хөрсний ялзмаг гэдэг нь ургамал болон амьтны гаралтай үлдэгдэл материалын задралаас хөрсөнд үүсдэг бараан өнгөтэй, эрдэс органикийн нийлмэл бодис юм. Ялзмаг нь өөртөө маш олон төрлийн шим тэжээлийн бодисыг (ялангуяа азотыг) агуулж байдаг учраас хөрсний үржил шимийн хамгийн чухал үзүүлэлт болдог. Ялзмагийн бодисын гол үүрэг ач холбогдол нь

хөрсний физик нөхцөлийг сайжруулдаг, чийгийн багтаамжийг нэмэгдүүлдэг, хамгийн сайн бүтэц үүсэхэд нөлөөлдөг, усанд уусамтгай үржил шимийн бодисуудыг тогтоон барих, хөрсөн дэх биологи ба микробиологийн идэвхийг сайжруулж ургамлын үндэсний хөгжилтийг дэмждэг, хөрсөн дотор явагдах химийн урвалуудад буффер (зохицуулагч)-ийн үүрэг гүйцэтгэдэг, хөрсөн дэх организмын хүнс болон энергийн эх үүсвэр болдог, хөрсний агаар солилцоог сайжруулдаг зэрэг олон талын ач холбогдолтой байдаг. Хөрсийг ялзмагийн агууламжаар нь <1% маш бага, 1-2% бага, 2-5% дунд зэрэг, >5% их ялзмагтай гэж үнэлдэг. Судалгааны үр дүнгээс харахад цөлөрхөг хээрийн Аллювийн ширэгт хөрсний ялзмагийн агууламж 0-10 см гүнд 0.649% буюу маш бага, 10-60 см гүнд 1.131-1.462% буюу бага агууламжтай байна. Хөрсний ялзмагийн хэмжээ доод үе давхаргадаа ихсэх хандлагатай байдаг нь говийн хөрсний онцлог бөгөөд энэ нь үндэсний хуваарилалттай холбоотой юм.

*Хөрсний цахилгаан дамжуулалт (EC).* Хөрсний цахилгаан дамжуулах чанар нь хөрсөн дэх усанд хялбар уусах давсны хэмжээг (хөрсний давсжилт) тодорхойлдог үзүүлэлт юм. Хөрсөн дэх илүүдэл давс нь хөрс-усны тэнцвэрт байдалд нөлөөлж ургамлын өсөлтийг сааруулдаг. Мөн хөрсний EC-ийн үр дүнд тулгуурлан хөрсний давсжилтыг хянах, давсажсан хөрсийг сайжруулах зэрэг ажлыг хийдэг. Хөрсийг EC-ээр нь 0.0-0.26 dS/m сул давсархаг, 0.26-0.77 dS/m дунд зэрэг давсархаг, 0.77-1.78 dS/m их давсархаг, 1.78-3.55 dS/m маш их давсархаг, >3.55 dS/m хэт их давсархаг гэж үнэлдэг.

*Хөрсний хөдөлгөөнт фосфор, кали ($P_2O_5$, $K_2O$).* Хөрсний азот, фосфор, кали (N, P, K) нь ургамлын шим тэжээлийн хамгийн чухал анхдагч макро элементүүд бөгөөд эдгээрээс нэг нь л дутагдахад ургамал ургах боломжгүй болдог. Хөрсөн дэх фосфорын пентоксид ($P_2O_5$) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Фосфорын пентоксидыг агууламжаар нь <2мг/100г бол бага хангамжтай, 2-4мг/100г бол сайн хангамжтай гэж үнэлдэг. Хөрсөн дэх калийн исэл ($K_2O$) нь ургамалд хамгийн хялбар ашиглагддаг. Калийн исэл ($K_2O$)-ийг агууламжаар нь <10 мг/100г бол бага хангамжтай, 10-20 мг/100г бол дундаж хангамжтай гэж үнэлдэг.

Шинжилгээний дүнгээс харахад хөрсний урвалын орчин хүчтэй шүлтлэг, карбонатгүй, ялзмагийн агууламж дунд зэрэг, сул давсархаг, хөдөлгөөнт фосфорын хангамж болон калийн хангамж сайн. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж.

*Хүснэгт 3. Хөрсний үржил шимт чанар*

| Зүсэлтийн дугаар | Гүн, см | pH | Давс, % | Cond, dsm | $CO_2$,% | Ялзмаг, % | Солилцох суурь, мг-экв/100 гр | | | Шим тэжээлийн элементүүд, мг/100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ca+Mg | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| Зүсэлт-1 | 0-20 | 8.51 | 0.06 | 0.111 | 0.00 | 2.64 | 30.2 | 24.0 | 6.2 | 7.8 | 51 |

***Хөрсний ширхгийн бүрэлдэхүүний онцлог шинж:*** Задлан шинжилгээний дүнгээс харахад (sandy loam) элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрс байна.

*Хүснэгт 4. Хөрсний механик шинж чанар*

| Зүсэлтийн дугаар | Гүн, см | Механик бүрэлдэхүүн, % (мм-ээр) | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Зүсэлт-1 | 0-20 | 19.4 | 49.4 | 16.1 | 5.1 | 6.8 | 3.2 | 15.1 |

### *Хөрсний бохирдол*

Судалгааны талбайд асгарсан шатах тослох материал ажиглагдаагүй. Талбайн дийлэнх хэсэг барилга байгууламж барьсан, хатуу хучилттай болгосонтой холбоотойгоор хөрсөн бүрхэвч дарагдсан байна.

*Хүснэгт 5. Хөрсний хүнд элементийн агууламж*

| Зүсэлтийн дугаар | Гүн, см | Хүнд металлын агууламж, мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ni | Cd | Pb | Cu | Zn | Cr |
| Зүсэлт-1 | 0-20 | 20.6 | - | 33.7 | 15.2 | 59.5 | 12.4 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/ | | 60 | 1 | 50 | 60 | 100 | 60 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | 1000 | 10 | 500 | 500 | 600 | 400 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | 1800 | 20 | 1200 | 1000 | 1000 | 1500 |

Хөрс судлалын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр дээрх элементүүд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу хөрсний хүнд металлын бохирдолгүй байна.

### *3. Усны чанар*

Төслийн талбай орчмын нутаг дэвсгэр нь төвлөрсөн усан хангамжийн нэгдсэн системд холбогдоогүй тул усны хэрэглээгээ өөрсдийн гаргасан 3 гүний худгаас хангадаг.




*Зураг 11. Гүний худгуудын байршил*

2018, 2021, 2025 онд тус төслийн хийгдэж байсан шинжилгээний хариуг 2021 онд хийгдсэн шинжилгээтэй харьцуулан үзлээ.

*Хүснэгт 6. Усны шинжилгээний үр дүн*

| Байр-шил | Он | $Cl^-$ | $SO_4^-$ | $NO_2^-$ | $NO_3^-$ | $CO_3^-$ | $HCO_3^-$ | $Na^++K^+$ | $Ca^{++}$ | $Mg^{++}$ | $NH_4^+$ | $Fe^{++}$ | $Fe^{+++}$ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Анионы хэмжээ (мг/дм³) | | | | | | Катионы хэмжээ (мг/дм³) | | | | | |
| Төв оффис | ***2018*** | 35.5 | 30.0 | 0.0 | 4.0 | 0.0 | 170.8 | 15.9 | 58.1 | 10.9 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | ***2021*** | 28.4 | 50.0 | 0.0 | 4.0 | 0.0 | 152.5 | 20.9 | 54.1 | 9.7 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | ***2025*** | 30.2 | 41.0 | 0.0 | 14.0 | 0.0 | 176.9 | 25.1 | 57.1 | 10.8 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Түрээс | ***2018*** | 46.2 | 40.0 | 0.0 | 6.0 | 0.0 | 189.1 | 17.9 | 71.1 | 12.2 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | ***2021*** | 28.4 | 35.0. | 0.0 | 4.0 | 0.0 | 189.1 | 25.2 | 58.1 | 8.5 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | ***2025*** | 39.8 | 52.0 | 0.0 | 18.0 | 0.0 | 237.9 | 33.2 | 78.4 | 12.6 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Баруун оффис | ***2018*** | 42.6 | 37.0 | 0.0 | 6.0 | 0.0 | 176.9 | 14.2 | 67.1 | 12.2 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | ***2021*** | 28.4 | 35.0 | 0.0 | 6.0 | 0.0 | 183.0 | 21.3 | 56.1 | 10.9 | 0.0 | 0.0 | 0.0 |
| | ***2025*** | 40.5 | 47.0 | 0.0 | 20.0 | 0.0 | 231.8 | 34.3 | 75.4 | 12.0 | 0.0 | 0.0 | 0.0 |

2018 оны шинжилгээгээр 3 худгийн ус нь гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 3 төрлийн ус бөгөөд чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. “Ундны усны чанарын стандарт MNS 900:2005” стандартын шаардлагыг хангаж байна.

2021 онд хийлгэсэн шинжилгээгээр дээрх 3 худгийн ус нь гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн 2 төрлийн ус бөгөөд чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. “Ундны усны чанарын стандарт MNS 0900:2018” стандартын шаардлагыг хангаж байна.

2025 оны шинжилгээгээр химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

Төслийн хашаанд гаргасан 3 худгийн ус нь ундны стандартын шаардлага хангасан ус байна. Дээрх хугацаанд усны төрөл өөрчлөгдсөнөөс өөр өөрчлөлтгүй байна.

## 2.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | Ус ашиглуулах дүгнэлтийг Нийслэлийн байгаль орчны газраар гаргуулах | Нийслэлийн Байгаль орчны газраар 2025 оны 09-р сарын 01-ны өдөр Е-2507-000084 тоот дүгнэлт гаргуулсан. | Дүгнэлтийг хавсаргав. |
| 2. | Дүүргийн ЗДТГ-тай Ус ашиглах гэрээ байгуулах | БГД-ийн ЗД-тай 2025.10.29-ны өдөр 442 тоот гэрээ хийсэн. | Гэрээг хавсаргав. |
| 3. | Хаягдал усны дүгнэлтийг Туул голын сав газраар гаргуулах | Туул голын сав газраар 2025.03.14-нд Е-2503-000189, Е-2503-000184 тоот дүгнэлт гаргуулсан. | Дүгнэлтийг хавсаргав. |
| 4. | Эрх бүхий байгууллагаар Байгаль орчны аудит хийлгэх | Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж байна. | БО-ы Аудитын гэрээг хавсаргав. |
| 5. | Нийгмийн хариуцлагын хүрээнд харьяа хороотой харилцан тохиролцож санал хүсэлтийг шийдвэрлэх | БГД-ийн хорооны иргэдтэй хэд хэдэн удаа уулзаж, үйл ажиллагааны талаар танилцуулж, зарим шаардлагатай зүйлсээр тусламж үзүүлсэн. Хороонд сандал, шаардлагатай зүйлсээр тусалсан.<br>Нийслэлийн Ерөнхий Боловсролын 92, 104-р сургуулиудад “Эрхэм нандин” төслийг хэрэгжүүлсэн. | Хийсэн ажлын талаар мэдээллийг доор оруулав. |
| 6. | Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх | Төслийн БОННҮ-ий нэмэлт тодотгол тайланг мэргэжлийн байгууллага болох “Эко Хайрхан консалтинг” ХХК-аар хийлгэж байна. | Гэрээг хавсаргав. |







*Зураг 12. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлууд*

















*Зураг 13. 🌸ЭРХЭМ НАНДИН ТӨСӨЛ🌸*

🌸ЭРХЭМ НАНДИН ТӨСӨЛ 🌸 2024–2025 оны хичээлийн жилд хэрэгжих өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төслийн хүрээнд Үе тэнгийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа.

Тус сургалтад Нийслэлийн Ерөнхий Боловсролын 92, 104-р сургуулийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн багш, эмч, өсвөр насны охидын клубийн хүүхдүүд хамрагдаж бэлтгэгдлээ. Үе тэнгийн сургагч багш нар маань АШУҮИС, МУБИС-ийн сайн дурын оюутнууд болон сургуулийн Зөвлөх багийн гишүүдийн чиглүүлэг дор зорилтот сургуулийн 1,200 охидод бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг сургалтаар дамжуулан түгээсэн. Энэхүү арга хэмжээнд Barloworld Mongolia ХХК-ийн Нийгмийн хариуцлагын хөрөнгө оруулалтын хорооны ажлын алба хүрэлцэн ирж, охидууддаа амжилт хүслээ.

“Барловорлд” ХХК-ийн үйлчилгээ дэмжих газрын захирал Т.Жанибек өөрийн биеэр очиж уулзаж ярилцсан.

## 2.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Хэрэгжүүлэн төлөвлөгөө | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | БОМТ-ий биелэлтийн тайланг харьяа хороо, байгаль орчны газарт танилцуулах | Хэвлэмэл болон цахим хэлбэрээр | Төслийн үйл ажиллагааны талаар хорооны иргэдэд 2 удаа танилцууллаа. Хорооны удирдлагуудтай тогтмол хамтран ажиллаж, санал хүсэлтээ харилцан солилцож ажилладаг. | 11 дүгээр сарын 1 |

### Хорооны иргэдтэй уулзах, тайлагнах

Төсөл нь Баянгол дүүргийн 25 дугаар хороонд хэрэгждэг. Хавар, намар хорооны ахмадууд болон иргэдийг хүлээн авч иргэдэд төслөө танилцуулж, тэдний санал, хүсэлтийг авсан. Мөн 9 дүгээр сарын 24-нд хорооны байранд хурал зарлаж, 70 гаруй хүний бүрэлдэхүүнтэй хорооны иргэдийн нийтийн хурал хуралдаж, үйл ажиллагаагаа тайлагнасан.



*Зураг 14. Хорооны оршин суугчдын хүлээн авч уулзаж буй байдал*



*Зураг 15. 25-р хорооны иргэдийн нийтийн хурал, 2025.09.24*

*Иргэдийн нийтийн хурлын протоколыг хавсаргав.*

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2025 оны 03 сарын 10 өдөр
Шинжилгээ хийсэн: 2025 оны 03 сарын 12 өдөр
Сорьц авсан газрын нэр: Баянгол дүүрэг, 25-р хороо
"Барловорлд Монголиа" ХХК, түрээсийн оффис
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Эко хайрхан консалтинг" ХХК

Солбицол: X=47'54'21.65
Y=106'51'50.56

Гүн: м
Ундарга:

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Тодорхойлсон нь:

| Анион | 1дм$^3$ -д байгаа | | | Катион | 1дм$^3$ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 39.8 | 1.12 | 17.5 | $Na^++K^+$ | 33.2 | 1.44 | 22.6 |
| $SO_4^{--}$ | 52.0 | 1.08 | 16.9 | $Ca^{++}$ | 78.4 | 3.91 | 61.2 |
| $NO_2^-$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Mg^{++}$ | 12.6 | 1.04 | 16.3 |
| $NO_3^-$ | 18.0 | 0.29 | 4.5 | $NH_4^+$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $HCO_3^-$ | 237.9 | 3.90 | 61.0 | $Fe^{+++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| Дүн | 347.7 | 6.39 | 100.0 | Дүн | 124.2 | 6.39 | 100.0 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын
нийлбэр: 352.9 мг/ дм$^3$

Анион катионуудын
нийлбэр: 471.9 мг/ дм$^3$

Ерөнхий хатуулаг 4.95 мг-экв/ дм$^3$
pH: 7.03

EC: 586 µS/cm
TDS: 322 ppm

Исэлдэх чанар : 3.04 мг/ дм$^3$

**Физик шинж чанар**

Тунгалаг: 30 см
Өнгө: үгүй
Үнэр: үгүй
Амт: ***
Тунадас: үгүй
Булингаршил: 1.0 NTU

Усны найрлагын томъёо: $M_{0.4}\frac{HCO_3^-61\ Cl^-18\ SO_4^{2-}17}{Ca^{2+}61\ Na^++K^+23\ Mg^{2+}16}$

**Дүгнэлт**

*Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлага хангаж байна.*

***Жич:*** *Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Гүйцэтгэсэн: Химич, ЭШДаА:_______________/С.Эрдэнэчимэг/
Шинжилгээг
Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч: _______________/Д.Гэрэлт-Од/

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

## Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2025 оны 03 сарын 10 өдөр
Шинжилгээ хийсэн: 2025 оны 03 сарын 12 өдөр
Сорьц авсан газрын нэр: Баянгол дүүрэг, 25-р хороо
"Барловорлд Монголиа" ХХК, баруун оффис
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Эко хайрхан консалтинг" ХХК

Солбицол: X=47'54'19.76 Y=106'51'47.33

Гүн: м
Ундарга:

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Тодорхойлсон нь:

| Анион | 1дм$^3$ -д байгаа | | | Катион | 1дм$^3$ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 40.5 | 1.14 | 18.3 | $Na^++K^+$ | 34.3 | 1.49 | 23.9 |
| $SO_4^{--}$ | 47.0 | 0.98 | 15.7 | $Ca^{++}$ | 75.4 | 3.76 | 60.2 |
| $NO_2^-$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Mg^{++}$ | 12.0 | 0.99 | 15.9 |
| $NO_3^-$ | 20.0 | 0.32 | 5.2 | $NH_4^+$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $HCO_3^-$ | 231.8 | 3.80 | 60.9 | $Fe^{+++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| Дүн | 339.3 | 6.24 | 100.0 | Дүн | 121.7 | 6.24 | 100.0 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 345.1 мг/ дм$^3$

Анион катионуудын нийлбэр: 461.0 мг/ дм$^3$

Ерөнхий хатуулаг 4.75 мг-экв/ дм$^3$

EC: 580 µS/cm

pH: 7.10

TDS: 290 ppm

Исэлдэх чанар : 2.40 мг/ дм$^3$

**Физик шинж чанар**

Тунгалаг: 30 см
Үнэр: үгүй
Тунадас: үгүй
Өнгө: үгүй
Амт: ***
Булингаршил: 1.0 NTU

$$\text{Усны найрлагын томъёо: } M_{0.4}\frac{HCO_3^- 61\ Cl^- 18\ SO_4^{2-} 16}{Ca^{2+} 60\ Na^+ + K^+ 24\ Mg^{2+} 16}$$

**Дүгнэлт**

*Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлага хангаж байна.*

***Жич:*** *Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Шинжилгээг Гүйцэтгэсэн: Химич, ЭШДаА: С. Эрдэнэчимэг /С.Эрдэнэчимэг/

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч: /Д.Гэрэлт-Од/

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

## Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2025 оны 03 сарын 10 өдөр
Шинжилгээ хийсэн: 2025 оны 03 сарын 12 өдөр
Сорьц авсан газрын нэр: Баянгол дүүрэг, 25-р хороо
"Барловорлд Монголиа" ХХК, төв оффис
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Эко хайрхан консалтинг" ХХК

Солбицол: X=47'54'20.97 Y=106'51'54.1

Гүн: м
Ундарга:

Уст цэгийн төрөл ба дугаар: Худаг

Тодорхойлсон нь:

| Анион | $1дм^3$ -д байгаа | | | Катион | $1дм^3$ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 30.2 | 0.85 | 17.6 | $Na^++K^+$ | 25.1 | 1.09 | 22.6 |
| $SO_4^{--}$ | 41.0 | 0.85 | 17.7 | $Ca^{++}$ | 57.1 | 2.85 | 59.0 |
| $NO_2^-$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Mg^{++}$ | 10.8 | 0.89 | 18.4 |
| $NO_3^-$ | 14.0 | 0.23 | 4.7 | $NH_4^+$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $HCO_3^-$ | 176.9 | 2.90 | 60.0 | $Fe^{+++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| Дүн | 262.1 | 4.83 | 100.0 | Дүн | 93.0 | 4.83 | 100.0 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 266.6 мг/ $дм^3$

Анион катионуудын нийлбэр: 355.1 мг/ $дм^3$

Ерөнхий хатуулаг 3.74 мг-экв/ $дм^3$

EC: 462 µS/cm

pH: 6.96

TDS: 231 ppm

Исэлдэх чанар : 3.84 мг/ $дм^3$

**Физик шинж чанар**

Тунгалаг: 30 см
Үнэр: үгүй
Тунадас: үгүй
Өнгө: үгүй
Амт: ***
Булингаршил: 1.0 NTU

$$\text{Усны найрлагын томъёо: } M_{0.3}\frac{HCO_3^-60\ Cl^-18\ SO_4^{2-}18}{Ca^{2+}59\ Na^++K^+23\ Mg^{2+}18}$$

**Дүгнэлт**

*Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь "Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018" стандартын шаардлага хангаж байна.*

***Жич:*** *Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Шинжилгээг

Гүйцэтгэсэн: Химич, ЭШДаА: __________ /С.Эрдэнэчимэг/

Хянаж баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч: __________ /Д.Гэрэлт-Од/

**"GREEN LAB "**

**ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ**

**СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС**

**Дээж ирсэн огноо:** 2025.03.14-20
**Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн:** " Эко Хайрхан Консалтинг " ХХК
**Холбоо барих дугаар:** 88007706
**Дээж авсан газар:** Улаанбаатар хот БГД-ийн 25-р хороо " Барловорлд Монголиа" ХХК Хүнд Машин Механизмын засвар үйлчилгээний төв

**Хөрсний химийн задлан шинжилгээний дүн / MNS3310:1991/**

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн см | pH | Давс , % | ЦДЧ | CaCO₃% | Ялзмаг % | Шингээгдсэн сууриуд, мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элемэнтүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 1 | 25/1664 | Дээж-1 | 0-20 | 8.51 | 0.06 | 0.111 | 0.00 | 2.64 | 24.0 | 6.2 | 7.8 | 51 |

**Хөрсний механик бүрэлдэхүүн /MNS 6824:2020/**

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2.0-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 25/1664 | Дээж-1 | 0-20 | 19.4 | 49.4 | 16.1 | 5.1 | 6.8 | 3.2 | 15.1 |

**Хөрсний хүнд металл /MNS ISO 11466:2007/**

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Хүнд металл мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Cd /Кадми/ | Cr /Хром/ | Ni /Никель | Pb /Хар тугалга/ | Zn /Цайр/ | Cu /Зэс/ |
| 1 | 25/1664 | Дээж-1 | 0-20 | - | 12.4 | 20.6 | 33.7 | 59.5 | 15.2 |
| Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ | | | | **1.5** | **100.0** | **100.0** | **70.0** | **150.0** | **100.0** |
| Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ | | | | **1.0** | **60.0** | **60.0** | **50.0** | **100.0** | **60.0** |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | **/MNS 5850:2019/** | | | | | |

Жич:Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувилан олшруулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжээч: /С. Мягмардаш/

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Лабораторийн эрхлэгч Г.Ганчимэг /M.Sc /

*Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9-р хороо, Алтайн гудамж 5 давхар оффис 2 давхар 243 тоот Утас/Факс : 72702020, 88950626 E-mail: landownermongolia@gmail.com*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР

УСНЫ ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-хороо, Чингүнжавын гудамж :Утас:70180075


# СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС
*/Test of result/*

**TL 092**
***MNS ISO 17025***

**Захиалагчийн нэр** */ Customer name /*: **''Барловорлд Монголиа''ХХК**

| **Шинжилгээний тодорхойлолт** */Analysis type/* | **Дээжний дугаар** */Sample number/* | **Дээжний хаяг, байршил** */Sample location/* | **Уст цэгийн төрөл** */Type of water* | |
|---|---|---|---|---|
| Бохир усны хими | № 348 | УБ хот, БГД, 25-р хороо, Төв оффисоос гарч буй бохир ус | Бохир ус | - |

| **Дээжний хэмжээ** */Quantity of sample/* | **Дээж хүлээн авсан огноо** */Receiving date/* | **Шинжилсэн огноо** */Analyzing date/* | **Хэвлэсэн огноо** */Printed date/* | **Техникийн шаардлага** */Technical requirements/* |
|---|---|---|---|---|
| 0.5л / 0.5L / | 2025.03.12 | 2025.03.12-03.26 | 2025.03.26 | **MNS 6561:2024** |

| **№** | **Үзүүлэлт** */Parameters/* | **Шинжлэх аргын стандарт** */Test method/* | **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ** */Technical specification/* | **Үр дүн** */ Test result/* |
|---|---|---|---|---|
| 1 | pH-Усны орчин /Hydrogen ions, mg/l / | MNS ISO 10523-2001 | 6-9 | 6.22 |
| 2 | Аммони, ($NH^{4-}$) мг/л /Ammonia, mg/l/ | MNS ISO 4428:1997 | 20.0 | **99.24** |
| 3 | Хлорид, $Cl^-$ , мг/л /Chloride $Cl^-$ mg/l / | MNS ISO 9297: 2007 | < 1000 | 177.25 |
| 4 | Сульфат $(SO4)^{2-}$мг/л / Sulfate, mg/l / | MNS ISO 6271:2011 | < 700 | 62.26 |
| 5 | Умбуур бодис, мг/л /TSS, mg/L / | MNS ISO 11923:2001 | < 400 | 362.00 |
| 6 | Химийн хэрэгцээт хүчилтөрөгч , (ХХХ) , мг/л /COD, mg/l / | ХТЛ-САЗ-4/02 | < 800 | **1336.60** |
| 7 | Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч , (БХХ) , мг/л /BOD, mg/l / | ХТЛ-САЗ-4/01 | < 400 | **514.07** |
| 8 | Нитрит ($NO_2$), мг/л / Nitrite, mg/l / | MNS ISO 4431:2005 | - | 0.00 |
| 9 | Нитрат ($NO_3$), мг/л / Nitrate, mg/l / | MNS ISO 7890-3:2001 | - | 4.05 |

Шинжилгээ гүйцэтгэсэн */Test performed by/* :
Химич */Chemist/*…………………………………………………………… Н. Халиунаа / *KHaliunaa.N MSc/*
Хянасан */Approved/*:
Лабораторийн эрхлэгч/ *Head of laboratory/* ……………………………… Д.Урантэс / *Urantes.D/*

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ УИТ0112



Сорилтын дүнгийн хуудас нь тухайн сорьцонд хамаарна. /The test result report is applicable to the sample/
Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал Авто тээврээс гарч буй ашигласан тосыг тээвэрлэх, цуглуулах ~~хадгалах, дахин боловсруулах~~ (зөвшөөрлийн төрөл) үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 9010001063 улсын бүртгэлийн дугаартай 2615134 регистрийн дугаартай "Хай би Ойл" ХК -д 2020 оны 06 дугаар сарын 29 -ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 29 -ны өдөр 5 жилийн хугацаагаар олгов.

**Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар 0000009

Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20-р баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд (гудамж, байшин, тоотын дугаар)

Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20-р баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд (газрын нэр/гудамжны нэр, дугаар)

**Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.**

**Зөвшөөрөл олгосон:**

| БОАЖ-ын сайд | [signature, stamp] | Н.Цэрэнбат |
|---|---|---|
| (байгууллагын нэр, албан тушаал) | (гарын үсэг, тамга) | (овог нэр) |

2020 оны 06 сарын 29 өдрийн

0000009 зөвшөөрлийн

1 хавсралт

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2020.06.29-ны өдрийн А/501 тоот тушаалыг үндэслэн олгов.

| (байгууллагын нэр, албан тушаал) | (гарын үсэг, тамга) | (овог нэр) |
|---|---|---|

**САНАМЖ:**

Тус яамнаас олгосон энэхүү гэрчилгээг зориулалтын бусаар ашигласан, үйл ажиллагаандаа ноцтой алдаа дутагдал гаргасан, худалдан борлуулсан, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол хүчингүй болгох үндэслэл болно.

“БАРЛОВОРЛД МОНГОЛИА” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.................................................. ШОН УОЛШ

“ТҮМЭН ЭГШИГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.................................................. Г.ЧИНЗОРИГ

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 11 сарын 29-ны өдөр №............ Улаанбаатар хот

Энэхүү аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол улсын Иргэний хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын **2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг тус тус үндэслэн болгон:

| (ҮҮСГЭГЧ)<br>“БАРЛОВОРЛД МОНГОЛИА” ХХК | (ХҮЛЭЭН АВАГЧ)<br>“ТҮМЭН ЭГШИГ” ХХК |
|---|---|
| Монгол Улс, Улаанбаатар 16030, Баянгол дүүрэг, 25-р хороо, Баруун үйлдвэрийн гудамж 133, Ш/Х-50<br><br>Регистрийн дугаар: 2077361<br>Утас: 976-70187588, 99094361<br><br>**Үүсгэгчийн эрх бүхий төлөөлөгч:**<br>Үйлчилгээ дэмжих газрын захирал<br>Т.Жанибек | Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14 хороо, Намьянжугийн гудамж 44-өөрийн байр<br><br>Регистрийн дугаар: 5031923<br>Утас: 88990428, 91918828<br><br>**Хүлээн авагчийн эрх бүхий төлөөлөгч:**<br>Ерөнхий менежер<br>Б.Одбаяр<br>chemicalwasterisk@gmail.com |

**Үүсгэгч болон Хүлээн авагч нь (тус тусад нь “Тал, хамтад нь “Талууд” гэх) энэхүү гэрээг байгуулж, доорх нөхцөлөөр харилцан тохиролцов.**

## НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичигт заасан олон төрлийн хаягдал /цаашид “аюултай хаягдал” гэх/-ыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.

1.2. Аюултай хаягдал хүлээн авагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.

1.3. Аюултай хог хаягдлын төрөл түүнийг устгах нэгж үнийг гэрээний Хавсралт №1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичигийг баталгаажуулан энэ гэрээнд хавсаргана.

1.4. Энэ гэрээ нь 2024 оны 12 сарын 02-ны өдрөөс 2025 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаатай байна.

1.5. Талууд зөвшилцөн гэрээний хугацааг анх байгуулсан хугацаагаар сунгаж болно.

## ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дараах зүйлийг тэмдэглэсэн байна. Үүнд:

2.1.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээг тавьсан байх;



Үүсгэгч тал: ............................... Хүлээн авагч тал: ...............................

2.1.2. Аюултай хог хаягдлыг савласан сав бүрт ямар хаягдал байгаа талаарх нэр шошготой байх;
2.1.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хөтлөн хүлээн авагчид шилжүүлэн өгөх;
2.1.4. Хүлээн авагч нь аюултай хог хаягдлыг "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлэж хүлээн авах ба тээвэрлэлтийн гэрээг талууд тусад байгуулна.
2.1.5. Хүлээн авагч нь аюултай шилжүүлэн өгөх үед тавигдах шаардлага, хог хаягдлыг хэрхэн хуримтлуулах талаар үүсгэгчид шаардлагатай мэдээлэл, зөвлөгөөг тухай бүр өгнө.

## ГУРАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР

3.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлын үүссэн хуримтлал, цаашид хуримтлал үүсгэхэд сав баглаа боодлын хүрэлцээгүй тохиолдолд Хүлээн авагчид шилжүүлнэ.
3.2. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ Хүлээн авагчид албан бичиг эсвэл и-мэйлээр 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.
3.3. Хүлээн авагч нь Үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
3.4. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах бүх зардлыг Хүлээн авагч тал хариуцна.
3.5. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэх, хүргэлтийн цэгт хүргэх тохиолдолд тээврийн үнийн саналыг Хүлээн авагчаас урьдчилан авч энэ гэрээний Хавсралт №2 баталгаажуулсан байна.
3.6. Талууд устгуулахаар шилжүүлсэн аюултай хаягдлын тоо хэмжээ, нэр төрлийг Хавсралт №3-аар баталгаажуулах бөгөөд тус баталгаажуулсан баримт, Хүлээн авагч талын нэхэмжлэхийг үндэслэн гэрээний төлбөрийг ажлын 10 хоногийн дотор Хүлээн авагчид шилжүүлнэ.

## ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

*4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:*
4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг Хүлээн авагчаас шаардах эрхтэй.
4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.4-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгнө.
4.1.3 Үүсгэгч нь аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, Тээвэрлэгчид 1 хувь, Хүлээн авагчид 2 хувийг илгээж, Хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
4.1.4 Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
4.1.5 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг Хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ.
*4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг*
4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.4-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.
4.2.2 Хүлээн авагч нь худалдан борлуулсан химийн хорт болон аюултай бодисоос үүдэлтэй хог хаягдлыг өөртөө шилжүүлэн авч, устгах, хадгалах, дахин боловсруулах ажлыг гүйцэтгэх, химийн бодисын хог хаягдалтай холбоотой аливаа асуудлаас үүсгэгчийг ангид байлгах үүрэгтэй.
4.2.3 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг Үүсгэгчид гаргаж өгнө.
4.2.4 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг шилжүүлэн авсанаас хойш түүний хадгалалт, дахин боловсруулалт, устгал зэргийг бүрэн хариуцна.
4.2.5 Үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

## ТАВ. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШИЛЖҮҮЛЭХ, ШИЛЖҮҮЛЭН АВАХ

5.1. Үүсгэгч аюултай хог хаягдлын мэдээллийг 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэн аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй.



Үүсгэгч тал: ..............................                Хүлээн авагч тал: ..............................

ТҮМЭН ЭГШИГ ХХК
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБА

5.2. Хүлээн авагч нь аюултай хог хаягдлаа "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлэн хүлээн авна.

5.3. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж Хүлээн авагч тал хүлээн авна.

5.4. Аюултай хог хаягдлыг ачиж, буулгах хүн хүч болон гарах зардлыг Хүлээн авагч тал хариуцна.

## ЗУРГАА. ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖИХ

6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.

6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг Хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх Хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.

6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний эрсдэл Үүсгэгчид байх ба Хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр эрсдэл Хүлээн авагчид шилжинэ.

## ДОЛОО. ХАРИУЦЛАГА, МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.

7.2. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэлт болон хадгалалтын зардлыг Үүсгэгчид төлнө.

7.3. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг Иргэний хууль болон энэ гэрээнд заасан журмын дагуу зохицуулна.

7.4. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт №1-д заасан тоо хэмжээ, аюултай хаягдлын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

7.5. Энэхүү гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Талуудын аль нэг нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Дээрх нөхцөл байдал болон түүний үр дагавар арилмагц үүргээ нэн даруй гүйцэтгэнэ. Тус нөхцөл байдалтай холбоотойгоор гэрээний хугацаанд өөрчлөлт орохоор бол хоёр тал харилцан тохиролцоно.

8.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэхүү гэрээ саатсан буюу хэрэгжих боломжгүй талаар хүсэлт гаргасан тал нь нотолсон тохиолдолд гэрээний нөгөө тал тус хугацааны алданги, торгууль нэмэлт үүргээс чөлөөлөгднө.

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг Үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг Хүлээн авагч хариуцна.

## ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг хадгална. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд зөвхөн бичгээр оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

Үүсгэгч тал: ..............................

Хүлээн авагч тал: ..............................

ТҮМЭН ЭГШИГ ХХК
ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБА

9.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, гэрээг дуусгавар болгох, хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл гэх зэргээр гэрээтэй холбоотой гаргаж буй аливаа мэдэгдэл, албан бичиг, санал, хүсэлтийг зөвхөн бичгээр баталгаажуулах ба талуудын албан ёсны хаягаар биечлэн, шуудангаар эсвэл албан ёсны электрон хаягаар хүргүүлнэ.

9.4. Талууд гэрээтэй холбогдон гарсан аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## АРАВ. АВЛИГЫН ЭСРЭГ БАРИМТЛАЛ

10.1 Гэрээний дагуу өөрсдийн үүргээ биелүүлэхдээ, Талууд, тэдгээрийн хамааралтай этгээд, ажилтан болон төлөөлөгч нь бусад аливаа этгээдийн үйлдэлд нь, эсхүл шийдвэрт нь нөлөөлөхийн тулд, эсхүл ямар нэгэн давуу байдал хүртэхийн тулд, эсхүл хууль бус зорилгод хүрэхийн тулд, шууд эсхүл дамжуулан төлбөр төлөхгүй байх, аливаа бэлэн мөнгөн дэвсгэрт, эд хөрөнгө амлахгүй, санал болгохгүй байх ёстой.

10.2 Гэрээний дагуу өөрсдийн үүргээ биелүүлэхдээ, Талууд, тэдгээрийн хамааралтай этгээд, ажилтан болон төлөөлөгч нь холбогдох хууль тогтоомжийн болон гэрээний зорилгын хүрээнд тухайн үйл ажиллагааг авлигал хээл хахууль өгөх, авах, бизнесийн авлигал, өдөөн хатгах гэх зэрэгт тооцогдох үйл ажиллагаа явуулахгүй байх ёстой бөгөөд тэр дундаа холбогдох хууль тогтоомж болон олон улсын гэрээ, эсхүл авилгийн болон хээл хахуулийн эсрэг, мөнгөн угаахын эсрэг стандартын шаардлагыг зөрчсөн үйл ажиллагааг хэрэгжүүлж болохгүй.

10.3 Хэрэв энэхүү заалтын нөхцөлийг зөрчсөн эсхүл зөрчигдөх магадлалтай гэж аль нэг тал сэжиглэж байгаа бол ийнхүү сэжиглэж буй тал нь аль болох богино хугацаанд нөгөө талдаа сэжигтэй зөрчлийн талаар бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Сэжиглэж буй тал нь бичгээр мэдэгдэхдээ энэхүү зүйлийн аль нэг заалт зөрчигдсөн эсхүл зөрчигдөх магадлалтай талаар бодит үйл баримтыг тодорхойлох ёстой, эсхүл сэжиглэх болсон үндэслэлийн тодорхойлох ёстой. Бичгээр мэдэгдэл хүргүүлмэгц, Сэжиглэж буй тал нь тухайн зөрчил гарсан, эсхүл гараагүй гэсэн тодруулгыг хүлээн авах хүртэлх хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх эрхтэй. Ийнхүү тодруулгыг хүлээн авах хугацааг тохиолдол тус бүрд нь тодорхойлно.

10.4 Талууд хээл хахууль, авлигын эсрэг холбогдох хууль тогтоомж, стандартыг дагаж мөрдөнө. Талууд авлигын үйл ажиллагаанд холбогдож болох аливаа гуравдагч этгээдтэй бизнесийн харилцаа үүсгэх эрсдэлийг аль болох багасгах, эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

10.5 Талууд өөрсдийн хууль бус үйлдэл, энэхүү зүйлийг зөрчсөн нь сөрөг үр дагаварт хүргэж болохыг хүлээн зөвшөөрч байна - зөрчил гаргагч талтай харилцахад ихээхэн хориглолтууд тавихаас эхлээд гэрээг цуцлах хүртэл сөрөг үр дагаварт хүргэж болохыг хүлээн зөвшөөрч байна.

10.6 Талууд энэхүү гэрээний авлигын эсрэг заалтыг биелүүлэхтэй холбогдуулж, түүнчлэн авлигын эсрэг заалттай холбоотой зөрчил, баримтын талаар мэдээлсэн аливаа этгээдийг сөрөг үр дагаварт оруулахгүй байхыг, зохих нууцыг чанд хадгалахыг хүлээн зөвшөөрч, батлав.



Үүсгэгч тал: ..............................

Хүлээн авагч тал: ..............................

ТҮМЭН ЭГШИГ ХХК
ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН САВ БАГЛАА БООДОЛ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭЗЭМШИЛ ҮЙЛДВЭР
ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБА

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ҮҮСГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ҮЙЛЧИЛГЭЭ ДЭМЖИХ ГАЗРЫН ЗАХИРАЛ

...............................................
Т.ЖАНИБЕК

САНХҮҮГИЙН ЗАХИРАЛ

...............................................
А.НЯМДОРЖ

КОРПОРАЦИЙН ХУУЛИЙН ЗӨВЛӨХ БӨГӨӨД ХУУЛИЙН ЗАХИРАЛ

...............................................
Д.ИНЖИНАШ

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

...............................................
Б.ОДБААТАР



Үүсгэгч тал: ...............................

Хүлээн авагч тал: ...............................

*“Барловорлд Монголиа” ХХК, болон“Түмэн эгшиг” ХХК-ийн хооронд байгуулсан 2024 оны 12 дугаар сарын 02 -ны өдрийн ...................... тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний Хавсралт №1*

**Аюултай хог хаягдлын нэгж үнэ**

| № | Аюултай хаягдлын төрөл | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгж үнэ /төг/ | Нэгж үнэ /НӨАТ/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр /0,5л, 1л, 2,5л, 5л, 10л, 25 | тн | 1 | 1,150,000 | 1,265,000 |
| 2 | Химийн хуванцар торх / 100л/ | ш | 1 | 4,800 | 5,280 |
| 3 | Химийн хуванцар торх /200л/ | ш | 1 | 7,900 | 8,690 |
| 4 | Химийн хуванцар IBC танк /1000л/ | ш | 1 | 28,000 | 30,800 |
| 5 | Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/ | тн | 1 | 1,250,000 | 1,375,000 |
| 6 | Төмөр торх боошиг | ш | 1 | 8,200 | 9,020 |
| 7 | Химийн бодисийн шил,сав | ш | 1 | 2,000 | 2,200 |
| 8 | Химийн хатуу хуурай хаягдал | кг | 1 | 5,600 | 6,160 |
| 9 | Химийн хаягдал шингэн уусмал 1литр | л | 1 | 6,000 | 6,600 |
| 10 | Хаягдал аккумлятор | ш | 1 | 4,000 | 4,400 |
| 11 | Масло шүүр том оврийн | ш | 1 | 2,800 | 3,080 |
| 12 | Принтерийн хор | ш | 1 | 2500 | 2,750 |
| 13 | Тосны шүүр | кг | 1 | 1800 | 1980 |
| 14 | Агаар шүүгч | кг | 1 | 2100 | 2310 |
| 15 | Хаягдал лаг | кг | 1 | 3,800 | 4,180 |
| 16 | Хаягдал цаас бохирдсон | кг | 1 | 600 | 660 |
| 17 | Хаягдал маск болон бээлий нийлэг материал | кг | 1 | 3000 | 3,300 |
| 18 | Хаягдал шингээгч даавуу химийн бодистой тостой | кг | 1 | 3,500 | 3,850 |
| 19 | Хаягдал төмөр материал болон бусад | кг | 1 | 2,500 | 2,750 |
| 20 | Хаягдал лааз сав | ш | 1 | 1100 | 1,210 |
| 21 | Хаягдал баттарей | кг | 1 | 3500 | 3,850 |
| 22 | Ашигласан масло, тос | л | 1 | 600 | 660 |
| 23 | Хөргөлтийн шингэн тосол | л | 1 | 1000 | 1,100 |
| 24 | Галын хорны баллон жижиг/ дунд | ш | 1 | 3500 | 3,850 |
| 25 | Галын хорны баллон том | ш | 1 | 4000 | 4,400 |
| 26 | Бохирдсон хөрс тостой | тн | 1 | 1,600,000 | 1,760,000 |
| 27 | Эмнэлгийн хаягдал | кг | 1 | 5500 | 6,050 |
| 28 | Хаягдал дугуй | том | 1кг | 400 | 440 |
| 29 | Хаягдал дугуй | жижиг | 1кг | 600 | 660 |
| 30 | Хар тугалганы хаягдал | кг | 1 | 1200 | 1320 |
| 31 | Нонель гуурс | кг | 1 | 950 | 1045 |

**Үүсгэгч талыг төлөөлж:**

“Барловорлд Монголиа” ХХК-ийн

Барилгын хэлтсийн менежер

..............................

**Хүлээн авагч талыг төлөөлж:**

“Түмэн эгшиг” ХХК-ийн

Ерөнхий менежер

..............................

ТҮМЭН ЭГШИГ ХХК ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН САВ БАГЛАА БООДОЛ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЛБА

ТҮМЭН ЭГШИГ ХХК САНХҮҮ 5534923 УЛААНБААТАР ХОТ

Ц.Энхжин

Б.Одбаяр

*"Барловорлд Монголиа" ХХК, болон"Түмэн эгшиг" ХХК-ийн хооронд байгуулсан 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ...................... тоот Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээний Хавсралт №3*

**Аюултай хаягдлыг хүлээлцэх баримт**

| № | Аюултай хог хаягдал нэр | Аюултай хог хаягдлын төрөл | Аюултай хог хаягдал хуримтлуулсан сав баглаа боодлын мэдээлэл | Үүссэн тоо хэмжээ /ш, кг, тонн/ | Аюултай хог хаягдлыг устгах нэгж үнэ | Аюултай хог хаягдлыг устгах нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| 1 | | | | | | |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |
| 4 | | | | | | |
| 5 | | | | | | |
| 6 | | | | | | |
| Нийт | | | | | | |

Нийт тээврийн зай .................................................. км байна.

*Аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгсөн:*

..........................................................

*Аюултай хог хаягдлын хүлээн авсан:*

..........................................................

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ**
**№**
**Дагалдах бичгийн дугаар**:

**1.Үүсгэгчийн талаарх мэдээлэл:**
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: Y- 001668
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: "........................" ХХК

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**
Овог нэр ............................. Албан тушаалтан ..................... Гарын үсэг: .................. Огноо: 2024он .......... сар.....өдөр

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: ......................... Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:.....................

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилаллын зэрэглэл | Савлагаа ны бүлэг | Савны | | Хэмжээ | Нэгж /кг Эсвэл/ ш | Аюултай хог хаягдлын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дугаар | Төрөл | | | |
| 1 | | | | | | | | |
| 2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | |
| 4 | | | | | | | | |

4. **Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**

6. **Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :**

1. Овог нэр:...................................... Гарын үсэг:.............................. 2022он ......... сар............өдөр

7. **Үл зохицол:**

**8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:**
Аж ахуйн нэгжийн нэр: **ТҮМЭН ЭГШИГ ХХК**
"Түмэн эгшиг" ХХК бүртгэлийн дугаар: **..........................**
**Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:**
Овог нэр : "Түмэн эгшиг" ХХК ............................. Албан тушаал ....................... Гарын үсэг/ тамга / ............................ Огноо 2022 он .... сар ... өдөр

*Approved as appendix of the Internal Labour Regulation in accordance with the Barloworld Mongolia LLC's Executive directors' order No 23/09-190 from the year of 2023.*

*"Барловорлд Монголиа" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 23/09-190 дугаар тушаалын дагуу Хөдөлмөрийн Дотоод Журмын хавсралтаар батлагдсан.*

# БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ
## *SUPPLIER CODE OF CONDUCT*

## 1. Barloworld Sustainable Procurement and Commitment to Suppliers

Barloworld Limited ("*Barloworld*") its subsidiaries and divisions (together the "*Group*"), are committed to creating value for all its stakeholders. Our principles of sustainable development – comprising of value creation, sustainable environmental performance and corporate social responsibility – are integral to our business strategy. Our approach to sustainable development includes how we work with our Suppliers. We integrate sustainable development into our procurement strategy, our day-to-day operations and relationships with Suppliers. The subsidiaries and divisions of the Group are required to identify, prevent and manage risks pertaining to Workplace Human Rights, Labour practices, including Fair remuneration practices, Health and Safety (H & S), Social responsibility and the Environment in their supply chain.

For purposes of this Supplier Code of Conduct, a "*Supplier*" is deemed to be any third party in the form of a bidder, vendor, contractor, consultant, agent or intermediary that is supplying or making an offer to supply ( in the form of a bid / tender / quotation or proposal) goods and or services or has been awarded a contract for the supply of goods and/or services to any Group company or the Group.

The Group seeks to engage in long-term relationships with Suppliers that are committed to sustainable development and ethical practices. Our goal is to partner with Suppliers to deliver value-for-cost procurement for the Group and its customers

## 1. Барловорлдын Тогтвортой Худалдан Авалт ба Бэлтгэн Нийлүүлэгчтэй Ажиллах Зарчим

Барловорлд Лимитед ("Барловорлд") -ийн охин компаниуд ба салбарууд (цаашид хамтад нь "Групп" гэх) нь бүх оролцогч талуудаа үнэ цэнийг бий болгох үүрэг хүлээдэг. Манай тогтвортой хөгжлийн зарчимд үнэ цэнэ бий болгох, хүрээлэн буй орчны тогтвортой байдал, компанийн нийгмийн хариуцлагыг багтаасан байдаг бөгөөд эдгээр нь бидний бизнесийн стратегийн салшгүй хэсэг юм. Тогтвортой хөгжлийн төлөөх бидний үйл ажиллагаанд Бэлтгэн Нийлүүлэгчидтэйгээ хэрхэн ажиллах талаар багтсан байдаг. Бид тогтвортой хөгжлийн зарчмыг худалдан авах үйл ажиллагааны стратеги, өдөр тутмын үйл ажиллагаа болон Бэлтгэн Нийлүүлэгчидтэй харилцах харилцаандаа нэвтрүүлсэн. Группийн охин компаниуд болон салбарууд нь ажлын байран дахь Хүний эрх, Хөдөлмөр эрхлэлт, үүнд шударга цалин хөлс олгох үйл ажиллагаа, Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Нийгмийн хариуцлага, Хүрээлэн буй орчны эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлж, оновчтойгоор удирдах үүрэг хүлээсэн байдаг.

Энэхүү Бэлтгэн Нийлүүлэгчийн Ёс Зүйн Дүрмийн хувьд "Бэлтгэн Нийлүүлэгч" гэдэг нь тендерт оролцогч, нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгч, зөвлөх, төлөөлөгч, зуучлагч хэлбэрээр Групп эсхүл Группийн салбар компанид бараа, ажил үйлчилгээ нийлүүлж байгаа эсхүл тендер, үнийн санал гаргасан эсхүл гэрээлэгчээр шалгарсан аливаа гуравдагч этгээд байна.

Групп нь тогтвортой хөгжлийн зорилттой, ёс зүйн хэм хэмжээг баримталдаг Бэлтгэн Нийлүүлэгчидтэй урт хугацааны харилцааг тогтоохыг эрмэлздэг. Бидний зорилго бол Бэлтгэн Нийлүүлэгчидтэй хамтран Групп болон харилцагч нарынхаа эрх ашгийг дээдэлсэн үнэ цэн-өртгийн оновчтой

and to demonstrate responsible supply chain management.

худалдан авалтыг хэрэгжүүлж, хариуцлагатай ханган нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх юм.

**Business Conduct**

When carrying out procurement duties and responsibilities, Barloworld employees are required to demonstrate their commitment to the Group's values as defined in the Barloworld Worldwide Code of Conduct. This is the minimum standard that our employees are required to adhere to with respect to ethical conduct, conflicts of interest, corruption, competition law and the handling of confidential and personal information, among other aspects. The Group's employees and stakeholders are encouraged to raise ethical issues and concerns using the appropriate communication and whistle-blowing channels provided by the Group.

**Бизнесийн зарчим**

Худалдан авах ажиллагааны үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхдээ Барловорлдын ажилтнууд Барловорлдын Ёс Зүйн Дүрэмд тодорхойлсон Группийн үнэт зүйлүүдэд нийцсэн үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай. Энэ нь ёс зүйтэй ажиллагаа, ашиг сонирхлын зөрчил, авлига, өрсөлдөөний тухай хууль, нууц болон хувийн мэдээлэлтэй харьцах талаар манай ажилтнууд дагаж мөрдөх ёстой ёс зүйн зайлшгүй хэм хэмжээ юм. Группийн ажилчид болон оролцогч талууд аливаа ёс зүйтэй холбоотой асуудлыг Группийн шугэл үлээх хэрэгсэл болон зохих сувгуудаар мэдээлэх боломжийг бүрдүүлж, дэмжиж ажилладаг.

**Supplier Relationship Management**

Barloworld has established a decentralized procurement functions across various divisions to conduct strategic sourcing and procurement activities in order to effectively and consistently manage relationships with Suppliers across the Group. The methodologies adopted ensure a fairness, equitability, transparency, competitiveness and cost-effectiveness sourcing and contracting process, according to the Barloworld policies and values.

**Бэлтгэн Нийлүүлэгчийн харилцааны менежмент**

Барловорлд нь Группийн хэмжээнд Бэлтгэн Нийлүүлэгчидтэй харилцах харилцааг үр дүнтэй, тууштай удирдан зохион байгуулах зорилтын хүрээнд тодорхой стратегитайгаар нийлүүлэлтийн эх үүсвэрийг тодорхойлох, худалдан авалтын үйл ажиллагааг эрхлэх хүрээн худалдан авалтын төвлөрсөн бус бүтэц, үйл ажиллагааг бүрдүүлсэн. Бидний нэвтрүүлсэн аргачлалууд нь худалдан авалтын болон гэрээ байгуулах үйл явцыг илүү шударга, тэгш, өрсөлдөөнт, ил тод, өртгийн хувьд оновчтой хангахад чиглэсэн бөгөөд Барловорлдын бодлого, үнэт зүйлсэд нийцсэн байдаг.

## 2. Compliance with the Supplier Code of Conduct

## 2. Бэлтгэн Нийлүүлэгчийн Ёс зүйн дүрэмд нийцсэн байх нь

The scope of this Code of Conduct is global and it applies to all Suppliers appointed in the Group and will be communicated to new and existing Suppliers. As part of the qualification and selection process, new suppliers will be assessed (through the Supplier Due Diligence process) to ensure adherence to the ethical standards within its supply chain and international best practices in human rights, health, safety, social responsibility and environmental standards,

Энэхүү Ёс зүйн дүрэм нь Группийн хэмжээнд, аль ч улсад гэрээлсэн бүхий л Бэлтгэн Нийлүүлэгчдэд хамааралтай бөгөөд шинэ болон идэвхтэй Бэлтгэн Нийлүүлэгч нарт бүгдэд нь танилцуулагдсан байх шаардлагатай. Бид сонгон шалгаруулах үйл ажиллагааныхаа хүрээнд шинээр сонгогдох Бэлтгэн Нийлүүлэгчдийг Групп эсхүл Группийн аль нэг компанид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ ханган нийлүүлэлтийн тогтолцоондоо ёс зүйн хэм хэмжээг, олон улсад тогтсон хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн хариуцлага, хүрээлэн

when undertaking its contractual obligations towards the Group or any Group company. Current Suppliers are prioritised for assessment based on the potential sustainability risk ranking associated with the goods and services delivered and including potential reputational risks from adverse media news coverage.

буй орчны стандарт, шилдэг туршлагыг дагаж мөрддөг эсэхийг (Бэлтгэн Нийлүүлэгчийн магадлан шинжилгээний процессын дагуу) үнэлдэг. Гэрээт Бэлтгэн Нийлүүлэгчдийг нийлүүлсэн бараа, ажил үйлчилгээтэй холбоотой тогтвортой байдлын эрсдэлийн зэрэглэл, түүнчлэн хэвлэл мэдээлэл дэх сөрөг мэдээллээс үүсэх нэр хүндийн эрсдэл зэрэгт тулгуурлан эрэмбэлэн үнэлдэг.

We enter into business relationships with Suppliers, who demonstrate our strong values of integrity, excellence, teamwork, commitment, and sustainability. Suppliers are required to commit to and uphold the ethical principles outlined in this Code of Conduct and to comply with sound business practices the Group embraces, comply with the law and conduct activities in a manner that respects human rights and is mindful of their impact on the environment. Suppliers are not expected to purchase products from or services from the Group for the purpose of gaining competitive advantage to become or continue to be a Supplier.

Бид манай үнэт зүйлс болох зарчимч байдал, шилдэг гүйцэтгэл, багийн ажиллагаа, хариуцлагатай байдал, тогтвортой байдал зэргийг дэмжин ажилладаг Бэлтгэн Нийлүүлэгч нартай бизнесийн харилцаанд ордог. Бэлтгэн Нийлүүлэгчид энэхүү Ёс зүйн дүрэмд заасан ёс зүйн зарчмуудад нэгдэж, тэдгээрийг баримтлах, Группийн хэрэгжүүлдэг бизнесийн зөв туршлага болон хууль тогтоомжид нийцсэн, мөн хүний эрхийг дээдэлсэн, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг чухалчилсан үйл ажиллагааг явуулах шаардлагатай. Бэлтгэн Нийлүүлэгчдийг шалгаруулалтад өрсөлдөх эсхүл Бэлтгэн Нийлүүлэгч хэвээр байхын тулд Группийн бараа, бүтээгдэхүүнийг худалдаж авах шаардлагагүй болно.

All Suppliers are required to ensure that they understand and comply with this Code of Conduct the communicate contents of this Code of Conduct to their employees, subcontractors and other business partners, who are involved in supplying products and services to the Group and to ensure their adherence.

Бэлтгэн Нийлүүлэгч нь энэхүү Ёс зүйн дүрмийн агуулгыг Группт бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ нийлүүлэхэд оролцдог бүхий л ажилчид, туслан гүйцэтгэгчид болон бусад бизнесийн түншүүддээ мэдээлж, эдгээр стандартыг дагаж мөрдүүлэх үүрэгтэй.

Barloworld and any Group company reserves the right, upon reasonable notice, to make such enquiries as it may deem appropriate to confirm compliance with the Code of Conduct. Suppliers shall cooperate with the Group to provide the information requested in a timely and clear manner.

Барловорлд болон Группийн салбар компаниуд нь энэхүү Ёс зүйн дүрэмтэй нийцэж байгаа эсэхийг тогтоохын тулд, үндэслэл бүхий мэдэгдэл өгч холбогдох тодруулга авах эрхтэй. Бэлтгэн Нийлүүлэгчид хүссэн мэдээллээ цаг тухайд нь тодорхой хүргэхийн тулд Групптэй хамтран ажиллана.

In the spirit of transparency and open reporting, if a Supplier becomes aware of any circumstance or action that is, or may be, a breach of this Code of Conduct, the Supplier will be required to report the matter to the Barloworld Group Ethics and Compliance

Ил тод, нээлттэй тайлагнах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд Бэлтгэн Нийлүүлэгч нь энэхүү Ёс зүйн дүрэм зөрчигдсөн болон зөрчигдсөн байж болзошгүй ямар нэгэн нөхцөл, үйлдлийн талаар мэдсэн бол Барловорлд Группийн Ёс зүй болон Нийцлийн Газарт (эсхүл салбар компанийн хариуцсан алба, хэлтэст) barloworld@ethics-line.com

department (or divisional equivalent) at barloworld@ethics-line.com.

хаягаар мэдэгдэх ёстой.

Barloworld reserves the right to investigate any alleged or actual breach of this Supplier Code of Conduct and a Supplier must not unreasonably refuse to cooperate in any such investigation. In this regard, Suppliers are required to provide Barloworld (or an appropriate third party appointed by Barloworld) with information and records that are reasonably required to investigate concern and grant reasonable access to their employees to provide statements and clarification if required as part of an investigations.

Барловорлд нь Бэлтгэн Нийлүүлэгчийн Ёс зүйн дүрмийг зөрчсөн эсхүл бодитоор зөрчигдсөн тохиолдолд судалгаа явуулах эрхтэй бөгөөд Бэлтгэн Нийлүүлэгч нь уг судалгаанд хамтран ажиллахаас ямар нэг үндэслэлгүйгээр татгалзах ёсгүй. Энэ тохиолдолд Бэлтгэн нийлүүлэгч нь Барловорлдод (эсхүл Барловорлдоос томилсон гуравдагч этгээд) асуудлыг судалж шалгах ажлын хэсэг гаргаж өгөх болон мэдээлэл, тодруулга өгөхийг ажилтнуудаа үүрэг болгох шаардлагатай.

Any breach of this Code of Conduct will be considered a material breach of contract by the Supplier and Barloworld and any Group company reserves its right of action under the terms of the relevant contract.

Энэхүү Ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд Бэлтгэн Нийлүүлэгч гэрээг ноцтой зөрчсөн гэж үзэх бөгөөд Барловорлд болон Группийн аль ч компани холбогдох гэрээний нөхцөлийн дагуу арга хэмжээ авах эрхтэй.

## 3. Legal and Ethical Standards

## Хууль ба Ёс зүйн стандартууд

Suppliers are expected to be aware of and shall comply with all laws applicable to its business and the laws of the countries in which they conduct businesses, and the laws applicable to the delivery of goods and services to Barloworld and any Group Company in the specific circumstances .

Бэлтгэн Нийлүүлэгч нь өөрийн бизнес, үйл ажиллагаа явуулж буй улс орон, тухайн бараа болон үйлчилгээнд тусгайлан хамаарах холбогдох бүхий л хууль, тогтоомжийн талаар бүрэн мэдээлэлтэй байж, нийцсэн үйл ажиллагаag эрхлэх шаардлагатай.

As a responsible corporate, Barloworld upholds the principles contained in the United Nations Global Compact (“*UNGC*”), and require Suppliers to support the 10 principles, as well as, the United Nations’ Universal Declaration on Human Rights, the International Labour Organisation’s Declaration of Fundamental Principles and Rights at Work.

Барловорлд Групп болон салбар компаниуд нь Бэлтгэн нийлүүлэгчдэдээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Даян Дэлхийн гэрээний 10 зарчим, түүнчлэн НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, мөн Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Хөдөлмөрийн хүрээн дэх суурь зарчим ба хөдөлмөрлөх эрхийн тухай тунхаглал зэргийг дэмжин ажиллахыг шаарддаг. Түүнчлэн Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Үндсэн зарчим, эрхийн тунхаглалыг баримталдаг.

Suppliers are also required to comply with applicable local and international anti-bribery and corruption legislation, as applicable to the delivery of goods and supply of services to Barloworld and any Group company on the specific

Бэлтгэн Нийлүүлэгч нь Барловорлд болон салбар компаниудад бараа бүтээгдэхүүн хүргэх, үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох олон улсын болон орон нутгийн авлига, хээл хахуулийн эсрэг хууль тогтоомжийг даган мөрдөх шаардлагатай.

Ялангуяа, Бэлтгэн Нийлүүлэгч нь доор дурдсан

circumstances.

Specifically, Suppliers are required to comply with the following minimum standards:

зайлшгүй мөрдөх шаардлагуудыг биелүүлэх ёстой:

**Health, Safety and Environment**

The Supplier shall comply with applicable health, safety and environmental laws. This includes other requirements e.g. , standards, policies and instructions designed to minimize negative impact to employee health and work environment . The Supplier recognises its responsibility towards the environment and maintains proper systems to prevent and/or minimise potential hazards, reduce its greenhouse gas emissions, improve efficiency of energy consumption, prevent pollution, drive responsible waste management and disposal practices, enhance resource efficiency, reduce negative impacts on biodivercity, promote land conservation and forestation. Suppliers shall provide a safe and healthy workplace for their employees and contractors. Suppliers must have documented health and safety policies and/or procedures in place together with appropriate safety infrastructure and equipment. This shall form part of the SHEQ file submitted to Barloworld and maintained continuously for relevance. Periodic reviews shall be conducted.

**Эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин**

Бэлтгэн Нийлүүлэгч нь осол, гэмтлээс сэргийлэхийн тулд холбогдох эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны хууль, захирамж, стандартуудыг мөрдөж эрүүл, аюулгүй ажиллах орчноор хангаж нийлүүлэлтийн тогтолцооны бүхий л хэсэгт аюулгүй байдлыг дэмжих хэрэгтэй. Үүнд: ажилчдын эрүүл мэнд, ажлын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахад чиглэгдсэн стандарт, бодлого заавар гэх мэт багтана. Бэлтгэн Нийлүүлэгч нь хүрээлэн буй орчны чиглэлээр хүлээх үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлаж, болзошгүй аюулыг багасгах эсхүл сэргийлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эрчим хүчний хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлэх, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хариуцлагатай хог хаягдлын менежментийг оновчтой горимыг мөрдөх, нөөцийн үр ашгийг дээшлүүлэх, биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, газар нутгийг хамгаалах, ойжуулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зохих тогтолцоог нэвтрүүлсэн байна. Бэлтгэн Нийлүүлэгчид нь өөрийн болон гэрээт ажилчдыг аюулгүй, эрүүл ажлын байраар хангана. Бэлтгэн Нийлүүлэгчид нь эрүүл ахуй, аюулгүй байдлын талаарх дүрэм журмыг баримтжуулж, аюулгүй ажиллагааны зохих дэд бүтэц, тоног төхөөрөмжийг бүрдүүлсэн байх ёстой. Энэ нь Барловорлдод ирүүлэх БОХАБЭА ба Чанарын тайлангийн нэг хэсэг бөгөөд байнгын хадгалагдана. Энэ талаар тогтмол зохих шалгалтыг явуулна.

**Physical Security**

Suppliers shall ensure that all necessary security arrangements are in place to protect their employees/contractors performing work at their sites, as well as their assets, especially in areas of political conflict. In particular, Suppliers are expected to have an actionable crisis management policy in place to be able to respond to emergencies (including national states of emergency) timely and efficiently.

**Биет аюулгүй байдал**

Бэлтгэн Нийлүүлэгчид нь өөрсдийн ажилчид, өөрийн талбайд ажил гүйцэтгэж байгаа туслан гүйцэтгэгчид, түүнчлэн эд хөрөнгөө хамгаалахын тулд аюулгүй байдлын бүх шаардлагатай зохицуулалтыг, ялангуяа улс төрийн мөргөлдөөн ихтэй газруудад бүрдүүлсэн байх ёстой. Мөн Бэлтгэн нийлүүлэгчид нь онцгой байдлын үед (улсын хэмжээнд зарласан онцгой байдал үүнд хамаарна) цаг алдалгүй, үр дүнтэй хариу арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн ослын үеийн менежментийн бодлогыг хэрэгжүүлсэн байх ёстой.

**Working Conditions**

Suppliers shall uphold fair and decent working conditions. Employees shall be paid at least the local industry rate or minimum wage stipulated by national law, whichever is higher, and benefit from social security schemes according to national legal standards. Should there be no legal minimum wage in the country of operation, fair and decent conditions imply that Suppliers shall pay their employees' wages benchmarked against the average wages earned in the country, the cost of living, social security benefits and the relative living standards.

**Хөдөлмөрийн нөхцөл**

Бэлтгэн Нийлүүлэгчид нь эрх тэгш бөгөөд зохистой хөдөлмөрийн нөхцөлийг хангана. Ажилчдын хөдөлмөрийн хөлсийг хууль тогтоомжид заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон тухайн орон нутгийн, тухайн салбарын хөлсний хэмжээний аль өндрөөр тогтоож, мөн дотоодын хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын тогтолцооны үр шимийг хүртээх ёстой. Үйл ажиллагаа явуулж буй улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоодоггүй тохиолдолд Бэлтгэн Нийлүүлэгчид нь эрх тэгш, таатай нөхцөлийг бүрдүүлэхдээ ажилчдынхаа цалинг тухайн улсын дундаж цалин, амьжиргааны өртөг, нийгмийн даатгал, холбогдох амьжиргааны төвшинтэй харьцуулж тогтоох ёстой.

**Freedom of Association and Non-Retaliation**

Suppliers shall not interfere with employee's freedom of association. Employee representatives shall not be subject to discrimination or termination of contract in retaliation for exercising employee rights, submitting grievances, participating in union activities, or reporting suspected legal violations. Where applicable, the Supplier should ensure that all employees are permitted to participate in collective bargaining, without fear of intimidation or reprisal and be free to choose whether or not to do so.

**Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хүндэтгэх ба хариу хохирол, дарамт үзүүлэхгүй байх**

